

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**  
**2011**





Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны үйл ажиллагааны тайлангаа Танд өргөн барьж байна.

2008 онд “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг Монгол Улсын Их Хурлаас баталсан. Тус баримт бичигт дурдсанаар Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат буюу 2007-2015 онууд, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үе шат буюу 2016-2021 онууд гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжихээр тооцоолсон.

Уг бодлого ёсоор Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэгч талууд нь иргэд, бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгэм, төр бөгөөд зах зээлд шударгаар өрсөлдөхийн тулд төрийн зүгээс иргэдийнхээ эрүүл, аюулгүй амьдрах, бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх таатай орчин нөхцөл бүрдүүлэх; банк, санхүүгийн зохистой, найдвартай тогтолцоо бий болгож, түүний эрүүл, ил тод орчныг хангах; төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцлийг бий болгох, бизнес, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн тогтолцоог хүнд сурталгүй, шуурхай болгох, эрх зүйн актын тоог цөөн байлгах асуудал юм.

Нөгөө талаас олон улсын нэр хүнд бүхий байгууллагууд, санхүүгийн томоохон шинжээчид, байгууллагуудаас манай улсын эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв байдлын талаар ихээхэн нааштай дүгнэлтүүдийг өгсөөр байна. Тухайлбал, Олон улсын валютын сангийн тооцоолсоноор 2016 он гэхэд Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 24 тэрбум ам.долларт хүрч дэлхийд 106-д бичигдэх бөгөөд нэг хүнд ногдох ДНБ 8000 ам. долларт хүрнэ. Эндээс харвал манай улс бусад бүх улсыг ардаа орхин дэлхийн хамгийн өндөр өсөлттэй улсын нэг болох юм.

Манай улсын тавьсан зорилт, бидний ирээдүйн талаар гадаад талаас дүгнэсэн дүгнэлтээс үзвэл бид гэрэл гэгээтэй, сайн сайхан хөгжлийг цогцлоох бүрэн боломжтой бөгөөд энэ зорилгод хүрэхэд улс орны санхүүгийн салбарын гол зохицуулагч байгууллагуудын нэг нь болох Санхүүгийн зохицуулах хороо чухал үүрэг гүйцэтгэнэ.

Энэ үүднээс Хороог чадавхжуулах, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, хүний нөөц болоод ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын бодлогыг оновчтой, үр дүнтэй тодорхойлон хэрэгжүүлэх ажлыг улам чанаржуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа болно. Иймээс 2012 онд болон ойрын ирээдүйд энэ асуудалд анхаарлаа хандуулж шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь бидний зорилт байх болно.

Энэ ажлаа бид цаг алдалгүй эхлүүлсэн бөгөөд юуны түрүүнд байгууллагынхаа стратегийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. Байгууллагынхаа эрхэм зорилго, стратегийн зорилт, үнэт зүйлсээ шинэчлэн тодорхойлж, эдгээртээ тулгуурлан ирээдүйн үйл ажиллагаагаа хэрэгжүүлснээр манай Хороо “Олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлсэн” байгууллага болно гэдэгтээ итгэл төгс байна.

Хүндэтгэсэн,

Д.Баярсайхан

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2011 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн Зохицуулах Хороо нь 2011 онд зохицуулалтын хүрээний салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоогоо сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх асуудлыг шинэ шатанд гаргах зорилттойгоор 5 газар, 4 хэлтэс, 1 алба ажиллаж, нийт 12 чиглэлээр 228 ажлыг төлөвлөн 94 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

2011 онд Санхүүгийн зохицуулах хороо 20 удаагийн ээлжит хуралдаанаар 434 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 417 тогтоол, 15 тэмдэглэл гаргаж, зах зээлийн зохицуулалтыг хийсэн байна. Хорооны нэг удаагийн хуралдаанд дунджаар 22 асуудал хэлэлцсэн байна.

Хороо нь тайлант онд нийт 10985 бичгийн эргэлттэй байснаас ирсэн албан бичиг 6834, гадагш явуулсан албан бичиг 3764, зохицуулалтын салбарын үйл ажиллагаатай холбоотой 387 өргөдөл, гомдол бүртгэгдэж шийдвэрлэгдсэн байна. Нийт өргөдлийн 316 өргөдөл буюу 81.7 хувь нь хувьцаа, ногдол ашиг, үнэт цаасны арилжаа болон түүний төлбөр тооцооны асуудлаар хандсан иргэдийн өргөдөл, гомдол байгаа нь энэ салбарын эрх зүйн орчинг шинэчлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2011 оны 6 дугаар сард Хорооны 172 дугаар тогтоолоор Хорооны Ажлын албаны дотоод бүтцийн нэгжүүд, ажилтнуудын орон тоог шинэчлэн тогтоосон. Уг тогтоол ёсоор Хороо дараахь бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.




Санхүүгийн зохицуулах хороонд тайлант оны жилийн эцэст нийт 104 ажилтан бүртгэлтэй байгаагаас 90 албан хаагч ажиллаж байна. Үүнээс Төрийн тусгай 3, Төрийн захиргааны албан хаагч 75, Төрийн үйлчилгээний албан хаагч 12, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.2-т заасан үндэслэлээр түр чөлөөтэй /сургалтын/-12, хүүхэд асрах чөлөөтэй 2 ажилтан байна. Нийт ажиллагсдын 46 нь эрэгтэй, 44 нь эмэгтэй, мэргэжлийн хувьд эдийн засагч 47 буюу 52 хувь, эрх зүйч 16 буюу 18 хувийг эзэлж бусад мэргэжлийн хүмүүс 30 хувьтай байна.

## ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААР

### 2.1. Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал


Тайлант оны байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нийт 252 удаагийн арилжаа явагдаж 148 компанийн 122.8 сая ширхэг хувьцаа 109.1 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын 2.4 сая ширхэг энгийн бонд 236.7 тэрбум төгрөгөөр, 1 компанийн 439.5 мянган ширхэг бонд 4.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагдаж нийт 350.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 125.6 сая ширхэг үнэт цаасыг арилжаалсан байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 257.4 тэрбум төгрөгөөр буюу 3.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Монголын хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар “Шарын гол” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 11,117 төгрөгийн үнэтэй 1,646,257 ширхэг хувьцааг 18,301,439,069 төгрөгөөр, “Силикат” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 225 төгрөгийн үнэтэй 16,222,300 ширхэг хувьцааг 3,650,042,500 төгрөгөөр тус тус арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 21.5 хувийг эзэлж байна. Энэ мэтээр цаашид blue chips буюу томоохон компанийн үнэт цаасыг зах зээлд гаргахыг дэмжих бодлого гарган ажиллаж байна.



Зах зээлийн үнэлгээ 2011 оны байдлаар 2,168,569,984,199 төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 794.6 тэрбум төгрөгөөр буюу 57.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


### Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)



2011 оны жилийн эцсийн дүнгээр зах зээлийн үнэлгээ хамгийн их компанид Таван толгой ХК /579.3 тэрбум/, АПУ ХК /312 тэрбум/, Багануур ХК /274.8 тэрбум/, Шивээ овоо ХК /205.3 тэрбум/, Шарын гол ХК /96.7 тэрбум/ зэрэг хувьцаат компаниуд орж байна.


Хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлж буй ТОП-20 индекс 2011 оны жилийн эцсийн дүнгээр 21,687.57 нэгж болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,927.76 нэгжээр буюу 46.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Топ - 20 индекс



### Төвлөрсөн хадгаламжийн мэдээ

2011 оны жилийн эцсийн байдлаар “ҮЦТТХТ” ХХК-д 17,941,104,608 ширхэг хувьцаа хадгалагдаж байгаагаас Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн хувьцаа 85 хувь, Хувийн өмчийн хувьцаат компанийн хувьцаа 14.2 хувийг, бусад үнэт цаас /бонд г.м./ 8 хувийг тус тус эзэлж байна. Нийт 7,470,900.0 ширхэг бонд хадгалагдаж байгаагаас 4,238,000 ширхэг нь Засгийн газрын бонд, 3,232,900.0 ширхэг нь компанийн бонд байна.



Засгийн газрын бонд нь төсвийн эх үүсвэрийг бүрдүүлэх ерөнхий зориулалтын болон тусгай зориулалтын буюу бодлогын арга хэмжээ (төсөл, хөтөлбөр)-г санхүүжүүлэх бонд гэсэн 2 төрөлтэй байдгаас тайлант онд Засгийн газраас ноос, ноолууран бүтээгдэхүүний салбарыг дэмжих чиглэлээр баталсан ноос, ноолуур хөтөлбөр, мөн төрийн албан хаагчийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд нийт 236.0 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн байна.

### Үнэт цаасны дансны мэдээлэл

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 129,138 данс нээгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 119,385 мянган дансаар нэмэгдсэн байна. Дансны тоо нэмэгдсэн шалтгаан нь “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 536 ширхэг хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх Засгийн газрын шийдвэр гарсантай холбоотой болно. Монгол Улсын хэмжээнд нийт өссөн дүнгээр авч үзвэл 564,550 ширхэг данс нээгдээд байна.

Он	Дансны төрөл			Харилцагчийн төрөл				Нийт	Холболт
	Шинэ	ХОЭБ	Хүсэлт	Иргэн		ААН			
				Монгол	Гадаад	Монгол	Гадаад		
2003	395	4350	3	4738	3	2	2	14605	9857
2004	450	6355	10	6786	9	10	-	44409	37594
2005	496	4431	12	4894	19	12	2	6780	1841
2006	2303	13908	22	16158	32	18	4	18435	2202
2007	50220	20579	41	70432	326	25	17	75290	4449
2008	2654	19077	77	21538	121	50	22	25320	3512
2009	671	8240	34	8803	74	25	9	10031	1086
2010	1310	4846	69	5884	203	46	23	9753	3528
2011	108909	4357	1212	113253	501	685	39	129138	14660

### Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчид

2011 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 88, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 22, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 17 компани ажиллаж байна.

## Мэргэжлийн оролцогчид



Хороо нь тайлант жилд нийт 40 компанид брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 5 компанид хөрөнгө оруулалтын зөвлөхийн болон андеррайтерийн тусгай зөвшөөрлийг нэмж олгосон байна. Мөн 20 компанийн үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасан.

“Бумбат Алтай”, “Санхүүгийн хөгжил инвест”, “Новел инвестмэнт”, “Очир Эрдэнэ”, “Гранддевелопмент”, “Финанс линк групп” ХХК зэрэг 6 компанийн гүйцэтгэх захирал томилох, “Нейшнл секюритиес”, “Гаули”, “Эс жи капитал”, “Скай хан капитал”, “Юу би би ди”, “Стандарт инвест”, “Грандлайн”, “Туушин инвест”, “Глобал траст секюритис”, “Монет капитал”, “Нортенсек”, “Санхүүгийн хөгжил инвест” зэрэг 12 компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлт, 5 компанийн оноосон нэрээ өөрчлөх асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

Хорооноос 2011 онд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, иргэдэд брокер, дилерийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх чиглэлээр орон нутагт салбар байгуулахыг дэмжиж ажилласан бөгөөд 6 компанид давхардсан тоогоор Архангай, Хөвсгөл, Дорноговь, Дархан уул, Орхон, Өмнөговь, Говь Алтай, Говь сүмбэр, Дорноговь, Өвөрхангай, Говь Сүмбэр, Дорноговь зэрэг 14 аймагт салбарын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олголоо.

## Хувьцаат компани


2011 оны жилийн эцсийн байдлаар 330 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэйгээс төрийн өмчийн 23, төрийн өмчийн оролцоотой 29, хувийн өмчийн 278 компани байна.

Тайлант онд “Шарын гол” ХК-ийн өрийг нэмж гаргах хувьцаагаар солих болон нэмж гаргах хувьцааг бүртгэх, “Силикат” ХК-ийн нэмж гаргах хувьцааг бүртгэх, хувьцааг хуваах, “Жаст Агро” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан 30 тэрбум төгрөгийн бондыг бүртгэлд бүртгэх, “Ремикон” ХК-ийн нэмж гаргах хувьцааг бүртгэх, Сүхбаатар аймгийн Засаг даргын нийтэд санал болгон гаргасан бондыг бүртгэлд бүртгэх зэрэг асуудлуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж, зохих шийдвэрийг гаргалаа.

Тайлант онд “Дөрвөн Уул”, “Монгол ном”, “Дархан гүрил тэжээл”, “Дархан орд харш”, “Жол”, “Монэнзим”, “Чандмань тал” зэрэг 7 ХК-ийн гаргасан үнэт цаасыг бүртгэлээс хассан ба “Шарын




гол” ХК-ийн хяналтын багцын хувьцааг эзэмшигчдээс нь ирүүлсэн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн хувьцааг худалдаж авахаар гаргасан саналыг зохих хууль журмын дагуу хянаж худалдаж авах доод үнийг тогтоон шийдвэрлэсэн болно.



### Хувьцаат компаниудын ногдол ашиг тараалт

Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байна.

Тайлант онд нийт 28 хувьцаат компани 74.25 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 58.4 хувиар өссөн байна.



## 2.2. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн талаар

Үнэт цаасны арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийг олон улсын жишигт хүргэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ:

а/ Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн биржтэй байгуулсан “Ажлын мастер гэрээ”-ний дагуу хөрөнгийн биржийн технологийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлж Миллениум Ай Ти арилжаа, хадгаламж, хяналтын программаас бүрдсэн цогц шийдлийн сервер, сүлжээ, дэд бүтцийн шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн. Үүнтэй холбогдуулан үнэт цаасны зах зээлд оролцогчдын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ арилжааны системийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны горимын талаарх мэдлэг олгох цуврал сургалтууд зохион байгуулагдаж, арилжааны шинэ программ суурилуулах ажил хийгдэж байна.

Мөн “МХБ” ХК-ийн гишүүнчлэлийн журам, электрон арилжааны журам, “ҮЦТТХТ” ХХК-ийн төлбөр тооцооны журмыг шинэчлэн найруулж, тус компаниудын ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлахад хамтран ажилласан. Түүнчлэн үнэт цаасны арилжаанд бодит цагийн хяналт тавих боломж бүхий Миллениум Ай Ти Сурвейланс системийг Хорооны мэдээллийн сүлжээтэй холбох бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэлээ.

б/ Хороо нь хуралдаанаараа Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын эрсдлийн удирдлагын талаар хэлэлцэн 2011 оны 245 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-д өөрчлөлт оруулж брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувиас доошгүй хэмжээгээр “эрсдлээс хамгаалах сан” байгуулж 2011 оны 10 сарын 01-ний дотор “ҮЦТТХТ” ХХК-ийн дансанд хөрөнгийг байршуулах ажлыг эхлүүлэх, “ҮЦТТХТ” ХХК нь тус сангийн хөрөнгийг зэрэглэл өндөртэй арилжааны банкинд байршуулахаар шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

в/ Үнэт цаасны зах зээлд оролцогчдын төлбөр тооцоог олон улсын жишигт хүргэх зорилгоор Монголбанк “ҮЦТТХТ” ХХК-ийг банк хоорондын гүйлгээний төлбөр тооцооны санхүүгийн дундын сүлжээнд холбох, гүйлгээг онлайн горимоор бодит цагт гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ.

Үүний үр дүнд хөрөнгийн зах зээлд оролцогчдын хувьцаа болон бондын арилжааны төлбөр тооцоог түргэн шуурхай, бодит цагт гүйцэтгэхээс гадна дараах давуу талууд бий боллоо. Үүнд:

- Төлбөр тооцооны нууцлал аюулгүй байдлын хувьд гүйлгээний мэдээ болон харилцах дансны мэдээлэл нь зөвхөн тухайн оролцогч тал тайлж унших, илгээх боломжийг бүрдүүлж аливаа эрсдлээс хамгаалсан;
- Төлбөр, тооцооны эрсдлийн хувьд “ҮЦТТХТ” ХХК нь харилцагчдын мөнгөн хөрөнгийг Монголбанкинд байршуулснаар төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой эрсдлийг арилгасан;
- Банкны сүлжээ систем нь төлбөрийг баталгаажуулах тул үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хийгдэж байгаа нь төлбөр хийгдээгүйтэй холбоотой эрсдлээс сэргийлнэ.

Үүний зэрэгцээ хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор “МХБ” ХК-ийн бүртгэлд бүртгэлтэй үнэт цаасыг ангилан арилжихаар тогтож, 2011 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс бирж дээр арилжаалагдаж буй хувьцааг арилжааны хоёр самбарт хуваах тухай шийдвэрийн дагуу самбар тус бүрийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлон өнөөгийн байдлаар А самбарт 36 ХК, Б самбарт 152 ХК-ийн үнэт цаасыг байршуулан арилжаалж эхэлсэн болно.

“МХБ” ХК-ийн арилжааны мэдээллийн санг өдөр, сар, улирлын, ТОП-20 индексийн үзүүлэлтийн өдөр тутмын арилжааны бүх хэлцлүүдийн жагсаалт, үнэт цаасны арилжааны сар бүрийн дүн,

сар тутмын идэвхитэй арилжаалагдсан 30 үнэт цаас, зах зээлийн үнэлгээ өндөр 30 үнэт цаасны арилжааны мэдээ, ханшийн хэлбэлзэл ихтэй байсан 20 үнэт цаасны талаарх сар тутмын мэдээ, брокер, дилерийн компани тус бүрийн арилжааны дүн гэсэн үзүүлэлтээр бүрдүүлээ.

### **2.3. Үнэт цаасны зах зээлийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалт хийх ажлын талаар**

Хороо нь тайлант хугацаанд үнэт цаасны мэргэжлийн оролцогчид болон хувьцаат компаниудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөө гаргаж батлагдсан удирдамжийн дагуу тодорхой ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд Архангай, Завхан, Төв, Орхон, Дархан-Уул аймгууд болон Улаанбаатар хотын 63 ХК-д, мэргэжлийн оролцогч 44 ХХК-д тус тус үзлэг шалгалт хийсэн байна. Мөн хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнөөс гадна үнэт цаасны зах зээлд оролцогч нэр бүхий 20 мэргэжлийн байгууллагад үзлэг шалгалтыг явуулж дээрх шалгалтын явцад илэрсэн нийтлэг зөрчил дутагдал дүгнэлт хийж, нэгдсэн танилцуулгыг Хорооны хуралдаанд танилцуулсан байна.

Шалгалтын үр дүнд илэрсэн зөрчлийг арилгуулахаар Улсын байцаагчийн 167 албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллаж, 24 удаагийн шийтгэврийг ногдуулснаас 13 хуулийн этгээдэд 1.75 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Бусад компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурлыг нь хуралдуулах, үйл ажиллагааг нь сэргээх эсэх, арилжааг нь сэргээх, эсхүл компанийг татан буулгах эсэх асуудлыг зохих хүсэлтэд нь тулгуурлан хянан шийдвэрлэж, зохих шаардлага анхааруулгыг өгч ажилласан байна. Арилжааг нь зогсоосон ХК-иудын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг 2011 оны жилийн эцсийн байдлаар хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын хавсралтад заасан арилжааг нь зогсоосон 165 хувьцаат компаниас			
Д/д	Зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилсөн ХК	Арилжаагаа сэргээх хүсэлт гаргасныг шийдвэрлэсэн ХК	Үлдсэн ХК
	29	17	119

Тайлант оны эхэнд Хороонд бүртгэлтэй нийт 336 ХК-иас ээлжит хурлын тухай мэдэгдэл, хурлын материалыг ирүүлээгүй 212 ХК-ийн нэрсийг гаргаж, хувьцаа эзэмшигчид, харилцагч байгууллагуудад нь тэдгээрийн удирдлагын бүрэн эрх дуусгавар болсон талаарх мэдээллийг Хорооны цахим хуудас болон өдөр тутмын сонин хэвлэлээр зарлан олон нийтэд мэдээлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагад зайны хяналт тавьсан талаар болон ХК-иудын 2010 оны жилийн тайлан, 2011 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын 2010 оны жилийн тайлан, 2011 оны улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл, танилцуулгыг бэлтгэн Хорооны хуралдаанд танилцуулж мэдээллийг Хорооны цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлэх, мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хийх зайны хяналтыг чанаржуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон зөрчил дутагдлыг арилгах талаар 2011 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн хариугаар 67 мэргэжлийн оролцогчид хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж хяналт тавин ажиллав.

Тухайн онд “ҮЦТТТХТ” ХХК-д хийгдэж байгаа арилжааны бус хэлцэл, үнэт цаасыг тусгаарласан, барьцаалсан гүйлгээнд хяналт тавьж, мэдээллийг нэгтгэн сан бүрдүүлж Хорооны удирдлагад танилцуулах ажлыг тогтмолжуулсан.

Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн журмын дагуу мэдээлэл, хяналтын FinA программ дээр мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар дараах мэдээллүүдийг санд оруулаад байна:

- Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл, түүний өөрчлөлтүүд;
- Мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгдсэн үзүүлэлтүүдийн нэгтгэл, түүний статистик шинжилгээ;
- Үнэт цаас гаргагчдын санхүүгийн тайлангийн нэгдсэн үзүүлэлтүүдийн нэгтгэл, түүний статистик шинжилгээ;
- ХК-иудын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийн биелэлтийн байдал.

#### **2.4. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар**

1997 оноос эхэлсэн компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон томоохон хувьцаа эзэмшигч, брокер, дилерийн зүгээс хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг зөрчсөн, түүнд хохирол учруулсан зэрэг хууль бус үйлдлүүдийн талаар иргэдээс өргөдөл, гомдол гаргах явдал байсаар байна.

Энэ талаар нийт 316 өргөдлийг хүлээн авч Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэж ирсэн болно.

Өргөдлүүдийн гол агуулга нь хувьцаа эзэмшигчдийн санал өгөх, ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарласан, татан буулгах үед компанийн хөрөнгөөс эзэмшиж буй хувьцаандаа ногдох ногдол хувь авах, хувьцааг нь хувьцаа эзэмшигч болох өмчлөгчийн зөвшөөрөлгүй худалдсан, бусдад шилжүүлсэн, компанийн хөрөнгийг үнэгүйдүүлсэн, хуульд заасан журам зөрчиж бусдад худалдсан, шилжүүлсэн, зээлийн барьцаанд тавьсан зэрэг асуудлыг шалгуулах, шийдвэрлүүлэхтэй холбоотой байсан.

Урьд жилүүдэд цагдаагийн байгууллагад шилжүүлээд байсан “Мөнхөд” ХХК-д холбогдох эрүүгийн хэрэгт албан ёсны шинжээчийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, холбогдох баримт материалд үндэслэн бусдад учруулсан хохирлын мөнгөн дүнг тогтоосон шинжээчийн дүгнэлт гаргаж, асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллалаа.

#### **2.5. Үнэт цаасны зах зээлийг сурталчлах, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар**

Хороо нь тайлант онд үнэт цаасны зах зээлийн талаар иргэд, олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, семинар, хурал зөвлөгөөн зохион байгуулж, иргэд, хөрөнгө оруулагчид, зах зээлийн оролцогчдыг хамруулах тал дээр анхаарч ажилласан.

“Үнэт цаасны зах зээл-Хөрөнгө оруулагчийн боловсрол” аяныг Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгуудад зохион байгууллаа.

“Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд гарч байгаа хэрэг маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг, Шихихутаг Дээд сургууль, Азийн хөгжлийн банктэй хамтран “Хөрөнгийн зах зээл” сэдэвт залуу судлаачдын онол практикийн бага хурлыг зохион байгуулж эдгээр уулзалт, бага хуралд тавигдсан илтгэл, оролцогчдын хэлсэн үгний эмхэтгэлийг хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгосон.

Германы техник туслалцаа, хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан “Хөрөнгийн зах зээл дээр гардаг эрүүгийн хэрэг, маргааныг шийдвэрлэх нь” семинар болон “Кастодиан үйлчилгээний танилцуулга, үйл ажиллагааны зарчим” сэдэвт сургалт, Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийн хүрээнд сургалт семинар, “Компанийн засаглал ба шинээр батлагдсан Компанийн тухай хууль”-ийн талаарх сургалтыг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа.

Монголын Хэвлэлийн хүрээлэнд “Хөрөнгийн зах зээл-Компанийн засаглал” сэдвээр сэтгүүлчдийн дунд сургалтыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсан.

Үнэт цаасны зах зээл дээр ажиллагсдад зориулсан семинар, уулзалт-ярилцлагыг мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудал, нийтэд санал болгон үнэт цаас гаргагчид тавих шаардлага, компанийн засаглалын зарчим, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэрэг асуудлаар зохион байгуулсан болно.

Хорооноос тайлант онд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад ажиллах боловсон хүчинд эрх олгох сургалтыг 5 удаа зохион байгуулж, нийт 770 хүн хамрагдсан бол эрх сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 82 хүн хамрагдлаа.

## **ГУРАВ. БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР:**


### **3.1. Банк бус санхүүгийн байгууллага**

Тайлант оны хувьд Банк бус санхүүгийн байгууллагын /цаашид ББСБ гэх/ үйл ажиллагааны тогтвортой байдлын үндэс суурийг бэхжүүлэх чиглэлээр зохицуулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эрх зүйн баримт бичгүүдийг олон улсын жишиг, стандартад нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулах замаар дэд бүтэц, эрсдэлд тулгуурласан хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгож, тус салбарын хөгжил, цаашдын тогтвортой байдлын үндэс суурийг бэхжүүлэх алхмуудыг эхлүүлсэн жил боллоо.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 195 ББСБ-ын 172 нь Улаанбаатар хотод, 23 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Мөн 17 ББСБ Япон, БНСУ, Итали зэрэг орнуудын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай байна.

Тайлант онд ББСБ-дын салбар, нэгжийн тоо 64, хувь нийлүүлэгчдийн тоо 602, ажиллагсдын тоо 1050 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 192.5 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна.

ББСБ-ын 2001 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш өнөөг хүртэл ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.




Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал
1	ББСБ-ын тоо	195
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	602
3	Ажиллагсадын тоо	1,057
4	Салбар нэгжийн тоо	64
5	Харилцагчдын тоо	192,577.0
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	205,409,535.1
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		2.19%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	119,004,471.9
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		2.13%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	138,182,359.6
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		20.41%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	116,519,924.0
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		44.11%
10	Нийт орлого /мянган төгрөгөөр/	46,348,113.1
11	Нийт зардал /мянган төгрөгөөр/	34,966,902.5
12	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	11,381,210.6
13	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	17
14	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	23
15	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	39

## Банк бус санхүүгийн байгууллагын нийт актив


### Нийт хөрөнгийн бүтэц



ББСБ-ын 2011 оны нийт актив өмнөх оны мөн үеэс 59.7 хувиар өсөхөд хуримтлагдсан ашиг, нийт өр төлбөр, дүрмийн сангийн /хувьцаат капитал/ өсөлтүүд гол нөлөөг үзүүлжээ.

Тайлант хугацаанд нийт активын 57.9 хувийг зээл, 31.3 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж байгаа нь нийт активын 89.2 хувь болж байна.

### Эргэлтийн хөрөнгийн бүтэц /хувиар/




	2007	2008	2009	2010	2011
Мөнгөн хөрөнгө	28.9	26.9	33.6	31.0	32.5
БХХОруулалт /цэврээр/	7.0	2.8	2.1	1.4	1.6
Зээл /цэврээр/	55.2	59.8	56.6	60.3	58.3
Санхүүгийн түрээсийн авлага /цэврээр/	0.0	0.0	1.2	1.5	0.4
Факторингийн авлага /цэврээр/	0.0	0.0	0.0	0.1	1.5
ӨБХөрөнгө /цэврээр/	0.5	0.1	0.4	0.6	0.2
Бусад хөрөнгө	8.4	10.4	6.1	5.1	3.4
Деривативийн авлага	0.0	0.0	0.0	0.0	2.0

2011 оны жилийн эцсийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 52.4 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 57.5 хувиар, чанаргүй зээл 29.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 40,918,655.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор чанаргүй зээлийн хэмжээ 1,389,063.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн мэт харагдаж буй боловч нийт зээлийн дүнд эзлэх чанаргүй зээлийн хувь 5.1 хувь болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.0 хувиар буурч чанаржсан эерэг үзүүлэлттэй байна.


### Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн багцын чанар

#### Нийт зээл, зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/



	2007	2008	2009	2010	2011
Хэвийн	32.7	41.5	47.4	70.7	111.4
Хугацаа хэтэрсэн	1.2	2.3	3.2	2.6	1.5
Чанаргүй	1.5	2.6	4.9	4.7	6.1
Нийт зээл	35.4	46.4	55.5	78.1	119

### Нийт зээл, зээлийн чанар /хувиар/



Графикаас үзэхэд зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан байна.

### Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүүгийн түвшин

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 195 ББСБ-аас 78,5 хувь буюу 153 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10 хувь, хамгийн бага хүү 0.4 хувь байна.

Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл, нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж дээд хүү 3.8 хувь, зээлийн дундаж доод хүү 2.1 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 2.9 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.


### БАНК, ББСБ-ЫН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИН






## Нийт эх үүсвэр

### Нийт эх үүсвэрийн бүтэц



	2007	2008	2009	2010	2011
■ Нийт өр төлбөр /тэрбум.₮/	18.4	23.5	21.6	36.6	67.2
■ Эзэмшигчдийн өмч /тэрбум.₮/	48.1	55.0	74.8	92.0	138.2
■ Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч /тэрбум.₮/	66.4	78.5	96.5	128.6	205.4
■ Нийт өр төлбөр /%/	27.6	29.9	22.4	28.5	32.7
■ Эзэмшигчдийн өмч /%/	72.4	70.1	77.6	71.5	67.3

### Эзэмшигчдийн өмчийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



	2007	2008	2009	2010	2011
■ Хувьцаат капитал	41.8	46.7	66.4	80.0	116.5
■ Бусад өмч	0.0	0.6	0.5	0.5	3.2
■ Сангууд	1.1	1.1	1.1	1.1	1.1
■ Хуримтлагдсан ашиг/алдагдал/	4.0	6.2	6.1	9.4	14.7
■ Хоёрдогч өглөг	0.5	0.4	0.8	0.9	2.7
■ Эзэмшигчдийн өмч	48.1	55.0	74.8	92.0	138.2

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 83.5 хувиар, эзэмшигчдийн өмч 50.3 хувиар тус тус өссөн байна.

2010 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 28.5 хувийг нийт өр төлбөр, 71.5 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2011 оны жилийн эцэст нийт өр төлбөр 32.7 хувь, эзэмшигчийн өмч 67.3 хувь болж өөрчлөгдсөн байна. Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлттэй харагдаж байна.

Дүрмийн сангийн өсөлтөд Хорооны 2008 оны “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн санг нэмэгдүүлсэн нь голлох үүрэг гүйцэтгэжээ.

Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсч байна.

### Банк бус санхүүгийн байгууллагын ашигт ажиллагаа


2011 оны жилийн эцсийн орлого өмнөх оны мөн үеэс 54 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлт зэрэг нь үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж улмаар үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлогын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна. Тайлант хугацааны нийт орлогын 65.4 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 46.7 хувиар өссөн/, 32.9 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 81.0 хувиар өссөн/ эзэлж байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 30.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 48.3 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 20.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 38.4 хувийг гадаад валютын арилжааны орлого, 43.2 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 52.2 хувиар өссөнөөс хүүгийн зардал 112.9 хувиар, хүүгийн бус зардал 50.7 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 64.5 хувиар, орлогын татварын зардал 58.3 хувиар тус тус өссөн. Харин болзошгүй эрсдэлийн зардал 5.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь зээл чанаржсан эерэг үзүүлэлт болж байна. ББСБ-ын 2011 оны жилийн эцсийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 54.0 хувиар, нийт зардал 52.2 хувиар тус тус өссөн байна. 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 11,381,210.6 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59.6 хувиар өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-уудын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлт тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэнтэй холбоотой юм.

Тайлант жилд 168 ББСБ буюу нийт ББСБ-ын 86.2 хувь нь ямар нэг хэмжээгээр ашигтай ажилласан ба тэдгээрийн нийт ашиг 13,915,991.9 мянган төгрөг байна. Ашигтай ажилласан ББСБ-уудын ашгийн арифметик дундаж ашиг 82,833.1 мянган төгрөг байна.

**Орлого, зарлага,  
ашигт ажиллагаа**  
/тэрбум төгрөгөөр/




■ Нийт орлого	13.8	18.8	26.6	30.1	46.3
■ Нийт зардал	11.1	14.9	21.7	22.9	34.9
■ Татварын дараах цэвэр ашиг	2.7	3.9	4.9	7.1	11.4

## 3.2. Хадгаламж, зээлийн хоршоо

### Зах зээлийн өнөөгийн байдал

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 4 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 21 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 9 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 47 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэснээр 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 162 хадгаламж, зээлийн хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс 71 нь Улаанбаатар хотод, 91 нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Хадгаламж, зээлийн хоршоод, тэдгээрийн гишүүдийн тооны өөрчлөлтийг сүүлийн 6 жилийн байдлаар харуулбал:




Тайлант хугацааны хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал
1	ХЗХ-дын тоо	162
2	Гишүүдийн тоо	26,882
3	Нийт актив	61,899,296.7
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	41,491,100.2
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%
5	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	43,842,608.5
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%
6	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	8,356,914.0
	Банкны салбарт эзлэх хувь	3.2%
7	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	4,833,193.9
8	Тухайн үеийн ашиг, алдагдал	2,159,916.8

Хадгаламж, зээлийн хоршоодын сүүлийн 5 жилийн байдлаар санхүүгийн тайлан тэнцлийн голлох үзүүлэлтүүд:

**ХЗХ - дын статистик мэдээлэл /тэрбум төгрөгөөр/**



	2007	2008	2009	2010	2011
■ Нийт актив	35.6	41.7	44.6	48.8	61.9
■ Нийт олгосон зээл	19.3	32.4	32.2	34.9	41.5
■ Татан төвлөрүүлсэн хадгаламж	25.9	27.7	29.9	34.8	43.8
■ Хувь нийлүүлсэн хөрөнгө	6.5	7.7	7.4	7.4	8.4
■ Хоршоологчдын өмч	0.8	3.2	4.5	3.9	4.8
■ Нийт орлого	10.5	12.7	14.5	12.5	13.4
■ Нийт зарлага	8.2	10.8	12.7	11.0	11.2
■ Нийт ашиг	2.3	1.9	1.8	1.5	2.2

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13,097,040.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,562,603.5 мянган төгрөгөөр, зээлийн багц 6,630,150.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Нийт зээлийн багцын муу зээлийн ангилалд ангилагдсан зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59,546.4 мянган төгрөгөөр өссөн харагдаж байгаа хэдий ч хадгаламж, зээлийн хоршоодын өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө болон зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байгаа нь зээлийн багцын чанар сайжирсантай холбоотой байна.

**Хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн багцын чанар**

ҮЗҮҮЛЭЛТ	2011.12.31	хувь	2010.12.31	хувь	ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ(ЦЭВРЭЭР)	39,313,755.5		32,325,996.4		6,987,759.1	21.6%
Нийт зээл	41,491,100.2	100.0%	34,860,950.1	100.0%	6,630,150.1	20.5%
Хэвийн зээл	38,032,190.4	91.7%	29,222,802.3	83.8%	8,809,388.1	27.3%
Хугацаа хэтэрсэн зээл	885,804.2	2.1%	2,104,254.4	6.0%	(1,218,450.2)	-3.8%
Чанаргүй зээл	2,573,105.6	6.2%	3,533,893.3	10.1%	(960,787.8)	-3.0%
Хэвийн бус	342,915.9	0.8%	883,242.8	2.5%	(540,327.0)	-1.7%
Эргэлзээтэй зээл	358,377.0	0.9%	838,384.2	2.4%	(480,007.2)	-1.5%
Муу зээл	1,871,812.7	4.5%	1,812,266.2	5.2%	59,546.4	0.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	(2,177,344.7)		(2,534,953.6)		357,609.0	1.1%

Нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,630,150.1 мянган төгрөгөөр буюу 20.5 хувиар өссөн.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,218,450.2 мянган төгрөг буюу 3.8 хувиар буурсан байна. Тайлант жилд муу зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59,546.4 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч чанаргүй зээлийн хэмжээ 960,787.8 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламжийн өөрчлөлт

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 10 хоршооны хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 37,746,174.1 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 86.1 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй нийт 24 хоршоо байгаа бөгөөд нийт хоршоодын 14.8 хувийг эзэлж, зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.



### Хадгаламж, зээлийн хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 999,488.9 мянган төгрөгөөр өсч, банкны салбарын 3,2 хувийг эзэлж байна. Сүүлийн 6 жилийн тоон мэдээллээс харахад тайлант жилд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ хамгийн ихээр өссөн байна.



### Хадгаламж, зээлийн хоршоодын ашигт ажиллагаа

2011 онд нийт орлогын хэмжээ 12,381,998.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 876,438.0 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар өссөн нь зээлийн хүүгийн орлого 1,201,399.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бусад орлого 270,818.8 мянган төгрөгөөр өсч, үйл ажиллагааны бус орлого 595,780.6 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт нөлөөлжээ.

Орлогын бууралтыг авч үзвэл үйл ажиллагааны бус орлого хэсгийн гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оны мөн үеийн байдлаас 476,952.9 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт ихээр нөлөөлсөн. Энэ нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль батлагдаж, хадгаламж, зээлийн хоршоод гишүүдээсээ гадаад валютаар хадгаламж татан төвлөрүүлэх, гадаад валютаар гишүүдээ зээл олгохыг хориглосонтой холбоотой.

Тайлант жилд нийт зардлын хэмжээ 11,222,081.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 199,419.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн. Үүнд хадгаламжийн хүүгийн зардал 1,023,631.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 382,345.1 мянган төгрөгөөр өсч, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 459,656.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 746,900.9 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт нөлөөлсөн байна.

### **Хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд**

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталснаар Монгол улс хадгаламж, зээлийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан хуультай боллоо. Ингэснээр Хадгаламж, зээлийн хоршооны талаар төрөөс баримтлах бодлого, зохицуулалт, хэрэгжүүлэх хяналтын тогтолцоотой болж, олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлэх боломжийг нээсэн чухал үйл явдал боллоо.

Хороо нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуультай нийцүүлэн “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам”, “Нягтлан бодох бүртгэлийн журам”, “Газар дээрх хяналт, шалгалт хийх журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын төслүүд боловсруулсан.

Тухайн жилд Хадгаламж, зээлийн хоршооны тухай бие даасан хуулийг батлуулахад гол анхаарлаа хандуулан ажилласнаас гадна хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Хоршооны тухай хууль, бусад хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа, улирлын санхүүгийн тайлан тэнцэлд зайны хяналтыг хэрэгжүүлж, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс давхардсан тоогоор 669 ХЗХ-нд тайлангийн хариуг хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд 178 ХЗХ-ны 2010 оны зохицуулалтын үйлчилгээний хөлсийг бүрэн төвлөрүүлж ажилласан.

Хороо нь хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлж батлагдсан удирдамжийн дагуу шалгалтаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж, нийт 40 ХЗХ-г хамруулан илэрсэн зөрчил дутагдалд үнэлгээ, дүгнэлт гарган 24 ХЗХ-нд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлтийг нь авч, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллалаа.

Түүнчлэн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн 5 ХЗХ-нд 550.0 мянган төгрөгийн захиргааны шийтгэл ногдуулж бүрэн төлүүлсэн.

### **3.3.Иргэдийн болон бичил санхүүгийн байгууллагуудын боловсон хүчний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд**

Санхүүгийн зах зээлийн хөгжил, цаашдын тогтвортой байдлыг хангахад иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд ББСБ, ХЗХ-ны үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн ил тод, шуурхай байдлыг хангах зах зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлж Хорооноос авч байгаа бодлогын арга хэмжээнүүд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, заавар болон тусгай зөвшөөрөл авсан буюу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон хуулийн этгээдийн талаар Хорооны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж, холбогдох төрийн байгууллагуудад албан тоотоор хүргүүлэн ажиллалаа.

Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ил тод болгож олон нийтэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд ББСБ, ХЗХ-ны улирал бүрийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн холбогдох мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулж, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Монголбанк, Сангийн яам, Статистикийн хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоонд тогтмол хүргүүлж байна.

Бичил санхүүгийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтны ур чадвар, чадавхийг дээшлүүлэх нь салбарын хөгжил, тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, эрсдэлийг бууруулахад нөлөөлөх чухал хүчин зүйл тул санхүүгийн чиглэлээр зохион байгуулагдсан гадаад болон дотоодын сургалт, семинар, зөвлөгөөнд мэргэжлийн байгууллагын боловсон хүчнийг өргөнөөр хамруулахад анхаарал тавьж ажиллалаа. Тухайлбал:

- Канадын хоршоодын холбооны төслийн хүрээнд ХЗХ-дын чадавхийг сайжруулах зорилготой

бүсчилсэн сургалтыг МХЗХХ, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв (МХСМТ)-тэй хамтран зохион байгуулж, төслийг бүрэн хэрэгжүүллээ. Уг арга хэмжээний хүрээнд МХСМТ-тэй хамтран Улаанбаатар хот, Завхан аймгийн Улиастай хотод “ХЗХ-ны нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудад зориулсан бүсчилсэн сургалт”-ыг зохион байгууллаа;

- Иргэдэд зориулсан гарын авлага 30000 ширхэг, салбарын нэгтгэл 300 ширхэгийг хэвлэн тус тус олон нийтэд тараасан ба Хорооны цахим хуудсаар байнга мэдээлэл хийж байна;
- Салбарын үйл ажиллагааны 5 жилийн үзүүлэлтээр судалгаа, тайлан бичиж Хорооны 5 жилийн товхимолд оруулсан;
- Цахим мөнгөний үйлчилгээний сургалтыг 2011 оны 7 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулж 220 гэрээт хамтрагч, төлөөлөгч нарыг хамруулж, Нарантуул захад 2011 оны 7 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд цахим төлбөр тооцооны үйлчилгээний талаарх өдөрлөг зохион байгуулсан;
- ББСБ-уудын гүйцэтгэх удирдлагын сургалтыг 10 дугаар сарын 07-ны өдөр, ББСБ-ын эдийн засагч нарт зориулсан сургалтыг 10 дугаар сарын 19-ний өдөр, ББСБ-ын нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус зохион байгууллаа.

### **3.4. Санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд**

Санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалахтай холбогдуулан бусад байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг тогтворжуулах, тогтмолжуулах, үр дүнг сайжруулахтай холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Азийн хөгжлийн банкнаас ХЗХ-дын чадавхийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэхээр Сангийн яам, АХБ, СЗХ харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд төслийг хэрэгжүүлэх ажиллагаа эхлээд байна;
- Олон улсын санхүүгийн хүртээмжийн холбоо /АФИ/-ны Мэдлэг солилцох хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлсэн;
- Канадын хоршоодын холбооны төслийн хүрээнд бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, төслийг бүрэн хэрэгжүүлж дууссан;
- Бичил санхүүгийн байгууллагуудын хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төслийг боловсруулж Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй Тогтвортой амьжиргаа төслийн харьяа Бичил санхүүгийн хөгжлийн санд хүргүүлсэн ба 2012 онд уг төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон;
- Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилтийг дүгнэн ажиллалаа;
- Хорооны зохицуулалтын хүрээнд хамаарагдах санхүүгийн байгууллагуудын Монголбанкны Зээлийн мэдээллийн санд хамрагдах явцыг дэмжих үүднээс зээлдэгчдийн талаарх мэдээллийг нийлүүлэх, холбогдох мэдээллийг авахад ашиглагдах санхүүгийн программ хангамжийн асуудлыг цэгцлэх, тэдгээрийг нэгдсэн программаар хангах асуудлыг шийдвэрлэсэн. Тус хороо Бичил санхүүгийн хөгжлийн сан, “Юу Эс Ай” ХХК-тай хамтран ажиллахаар тохиролцож улмаар “Монголбанкны Зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах Micro finance программ хангамж”-ийг зохиож, “Монголбанкны Зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах Micro finance программ хангамжийн гарын авлага”-ыг боловсруулж, Хорооны цахим хуудсанд байршуулсан ба уг программыг ашиглан мэдээллийн санд шаардлага хангасан 36 байгууллага холбогдоод байна;
- Архангай, Дорнод, Эрдэнэт, Баянхонгор, Өвөрхангай аймгийн төлөөлөгчдийн хүсэлтийн дагуу татан буугдсан ХЗХ-дын судалгаа, мэдээллийг хүргүүлэх арга хэмжээ авч ажилласан;

- 2011 онд зохицуулалтын байгууллагууд давхардсан тоогоор 999 тайлангийн хариугаар зөвлөгөө өгсөн ба 7 удаагийн сургалтаар нийт 982 иргэн, ажилтанд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, түдгэлзүүлсэн нийт 73 хуулийн этгээдийн талаар нийслэл, орон нутгийн татварын хэлтэс, УБЕГ-т мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зар хүргэж ажилласан;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны дагаж мөрдөх журам, зааврын эмхтгэлийг шинэчлэн боловсруулж, 300 хувь хэвлүүлэн, зохицуулалтын байгууллагуудад хүргүүлсэн;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай бие даасан хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2011 оны 12 дугаар сард хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хадгаламж, зээлийн хоршоодод хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор анхаарах зүйлсийн талаар зөвлөмж, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй хадгаламж, зээлийн хоршоодод хуулийг хуулбарлан хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хууль батлагдсантай холбоотойгоор хамтран ажиллах талаарх албан бичгийг хүргүүлээ. Цаашид Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хадгаламж, зээлийн хоршоодын улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэг болон дүрэм, журам, заавруудад хуулийн дагуу өөрчлөлт хийлгэх, бүх гишүүдийн хурлын баримт бичгийг хүлээн авч, хуулийн шаардлагад нийцсэн эсэхийг хянах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.
- Тайлант онд төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай болон Валютын зохицуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Хорооны бүрэн эрхийн хүрээнд болон төрийн байгууллагуудтай хамтарсан хяналт, шалгалтыг хийх чиг үүргийг хэрэгжүүлж үл хөдлөх хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Уг шалгалтад нэр бүхий 12 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсанаас “Осмо” ХХК, “Тэнхлэг зууч” ХХК, “Дельта зууч” ХХК, “Либерти бридж” ХХК, “Мастер пропортийз” ХХК, “Монголиан пропортийз” ХХК, “Ричмонд роунд” ХХК зэрэг 7 хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө зуучлан худалдах, түрээслэх үнийг Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр тооцох нэгж, ам доллараар илэрхийлж, гадаад валютаар төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлэн улсын байцаагчийн албан шаардлагаар сануулга өгч, бусад хуулийн этгээдэд улсын байцаагчийн албан шаардлагаар хуулийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.

## ДӨРӨВ. ДААТГАЛЫН САЛБАР

### 4.1. Даатгалын салбарын нэгдсэн үзүүлэлт

2011 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 188 даатгалын салбар, 2057 даатгалын төлөөлөгч, 8 даатгалын зуучлагч компани, 9 даатгалын хохирол үнэлэгч компани, 13 актуарч нийт 2104 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулсан байна.


#### Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2007-ИҮ	2008-ИҮ	2009-ИҮ	2010-ИҮ	2011-ИҮ
1	Даатгагч	15	16	18	17	17
	Даатгалын компанийн салбар	91	120	129	138	188
2	Даатгалын төлөөлөгч	690	1167	1676	2061	2057
3	Даатгалын зуучлагч	2	4	5	9	8
4	Даатгалын хохирол үнэлэгч	-	-	2	6	9
5	Даатгалын актуарч	-	9	10	12	13
	Бүгд	707	1196	1711	2105	2104



Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо 2011 оны жилийн эцэст 2010 оны мөн үеийнхээс үндсэндээ өөрчлөгдөөгүй хэвээр байна. Тайлант хугацаанд “Гранд даатгал” ХХК нь “Ард даатгал” ХХК-тай нэгдэж үйл ажиллагаа явуулсан, мөн “Мандал генерал” ХХК ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан.


### Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тоогоор



### Даатгагчийн хөрөнгө

Тайлант онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 81.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх 2010 оны мөн үетэй харьцуулахад 24.5 тэрбум төгрөг буюу 1,4 дахин өссөн байна. Мөн 2008 оны мөн үетэй харьцуулахад 46.9 тэрбум төгрөг буюу 2,3 дахин өссөн дүнтэй байна.

### Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2010 оны 4 дүгээр улиралд 47.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 83,3 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 9.5 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 16,4 хувийг эзэлж байсан бол 2011 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 65.6 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 80,7 хувь, эргэлтийн бус хөрөнгө 15.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 19,3 хувийг эзэлж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 1,4 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс өсч, эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин буурсан байна. Үүнд эргэлтийн бус хөрөнгө дэх үндсэн хөрөнгийн өсөлт, хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгийн өсөлтүүд нөлөөлсөн.

### Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2010.12.31		2011.12.31		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	47305.9	83.3	65560.6	80.7	18254.7	-2.6
Эргэлтийн бус хөрөнгө	9457.1	16.4	15672.8	19.3	6215.7	2.9
Нийт хөрөнгө	56763.0	100.0	81233.4	100.0	24470.4	

2011 оны жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн 59,5 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 28.2 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 11,1 хувийг дансны авлага, үлдэх 1,2 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 6,2 пунктээр, дансны авлага 0,7 пунктээр өсч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 5,3 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 1,6 пунктээр тус тус буурсан байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 18.2 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд үүнд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Моннис даатгал” ХХК, “Мандал генерал даатгал” ХХК-иудын дүрмийн сангийн мөнгөн хөрөнгө нөлөөлж байна.

### Эргэлтийн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2007		2008		2009		2010		2011	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15600.1	64.3	22162.2	74.8	23487.8	64.8	34241.1	72.38	39010.3	59.5
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3065.4	12.6	2862.2	9.7	7967.8	22.0	8560.4	18.10	18532.6	28.2
Дансны авлага	1979.8	8.2	2476.0	8.4	3754.2	10.4	3844.5	8.13	7243.3	11.1
Бусад эргэлтийн хөрөнгө	3625.2	14.9	2131.7	7.2	1024.9	2.8	659.9	1.39	774.3	1.2
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>24270.5</b>	<b>100.0</b>	<b>29632.1</b>	<b>100.0</b>	<b>36234.7</b>	<b>100.0</b>	<b>47305.9</b>	<b>100.0</b>	<b>65560.6</b>	<b>100.0</b>

2011 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харьцуулахад “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Мандал генерал даатгал” ХХК-ийн хөрөнгө даатгагчдын нийт хөрөнгийн 40,9 хувийг эзэлж, “Жонон даатгал” ХХК-ийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө хамгийн бага буюу зах зээлийн нийт хөрөнгийн 1,8 хувийг эзэлж байна.

/сая төгрөгөөр/


д/д	Компанийн нэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	“Жонон даатгал” ХХК	1,433.9	1.8
2	“Гэр даатгал” ХХК	1,627.9	2.0
3	“Моннис даатгал” ХХК	1,839.8	2.3
4	“Монре даатгал” ХХК	1,870.7	2.3
5	“Мөнх даатгал” ХХК	1,995.2	2.5

6	“Ган зам даатгал” ХХК	2,034.0	2.5
7	“УБ хотын даатгал” ХХК	2,101.6	2.6
8	“Нэйшнл лайф даатгал” ХХК	3,554.2	4.4
9	“Номин даатгал” ХХК	3,944.0	4.9
10	“Ард даатгал” ХХК	5,251.8	6.5
11	“Соёмбо даатгал” ХХК	5,419.7	6.7
12	“Практикал даатгал” ХХК	5,524.6	6.8
13	“Миг даатгал” ХХК	5,688.6	7.0
14	“Тэнгэр даатгал” ХХК	5,772.8	7.1
15	“Мандал женерал даатгал” ХХК	6,631.9	8.2
16	“Бодь даатгал” ХХК	6,955.8	8.6
17	“Монгол даатгал” ХХК	19,587.0	24.1
	Дүн	81,233.5	100.0

### Даатгалын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилээр жилийн эцсийн байдлаар харьцуулж харахад дараахь байдалтай байна.

#### Өр төлбөр, эзэмшигчийн өмч, нөөц сангийн харьцаа



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2009 оны 4 дүгээр улиралд 60,3 хувийг эзэлж байсан бол 2010 оны 4 дүгээр улиралд 51,4 хувь, 2011 оны 4 дүгээр улиралд 44,5 хувь эзлэх болж тус тус буурсан нь нэгдүгээрт, актуар тооцоололд хяналт тавих чадавхи сул, хоёрдугаарт, ашгаа өндөр гаргах гэсэн даатгалын компанийн ашиг сонирхолтой холбоотой байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2007 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн мөн онд 6,3 хувь байсан бол тайлант онд 6,1 хувь болж буурсан байна.

### Эзэмшигчдийн өмч

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/									
	2007		2008		2009		2010		2011	
Өр төлбөр	1785.3	6.3	8666.2	25.2	2390.5	5.8	2446.9	4.3	4949.3	6.0927
Нөөц сан	17784.4	62.7	15033.9	43.8	24744.6	60.3	29174.7	51.4	36144.3	44.494
Эзэмшигчийн өмч	8808.2	31.0	10630.1	31.0	13920.6	33.9	25142.3	44.3	40139.9	49.413
Дүн	28377.9	100.0	34330.2	100.0	41055.7	100.0	56763.9	100.0	81233.5	100.0

Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар тогтвортой өсч, мөн оны үеийнхээс 31,331.7 сая төгрөгөөр нэмэгдэж ирсэн бөгөөд энэ нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй уялдаатай байна.

### Даатгалын хураамжийн орлого


Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2011 оны жилийн эцсийн байдлаар 47,997.3 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,5 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 47,487.1 сая төгрөг, урт хугацааны даатгагч 510.3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 16,003.8 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 225.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 580,745.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын хэлбэрээр тайлант оны жилийн эцэст нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хөрөнгийн даатгал 4,180.5 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 4,966.2 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 2,939.6 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1,398.8 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1,787.9 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 955.7 сая төгрөгөөр, ачааны даатгал 304.7 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 137.1 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 83.9 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 22.1 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 332.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, барилга угсралтын даатгал 1,015.2 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 18.1 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 0.01 сая төгрөгөөр тус тус буурсан байна.


/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	Даатгалын хураамжийн орлого		Өөрчлөлт /+,./-/
	2010.12.31	2011.12.31	
1.2. Хөрөнгийн даатгал	8246.8	12427.3	4180.5
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	6914.1	11880.3	4966.2
1.8. Агаарын хөлгийн даатгал	2342.6	5282.2	2939.6
1.10. Хариуцлагын даатгал	4657	6055.8	1398.8
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3749.7	5537.6	1787.9
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	2070.5	3026.2	955.7
1.11. Санхүүгийн даатгал	1298.7	1630.9	332.2
1.5. Барилга угсралтын даатгал	1368.8	353.6	-1015.2
1.4. Ачааны даатгал	765.8	1070.5	304.7
2.1. Хугацаат амьдралын даатгал	191.8	173.7	-18.1
2.5. Эрүүл мэндийн даатгал	91.5	228.6	137.1
1.7. Мал амьтдын даатгал	69.3	222.4	153.1
1.6. Газар тариалангийн даатгал	0	0.01	0.0
2.3. Хуримтлалын даатгал	1.3	85.2	83.9
2.4 Тэтгэврийн даатгал	0.6	22.7	22.1
<b>Дүн</b>	<b>31 768.5</b>	<b>47 997.0</b>	<b>16 228.5</b>

### Даатгалын хураамжийн орлого



2001 оноос хойш 2011 он хүртэл нийт орлогын өсөлт 42.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 15.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь даатгалын хураамжийн орлого нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд даатгуулагчийн тоо өссөнтэй холбоотой юм.



Даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээг Дотоодын нийт бүтээгдэхүүний 2011 оны урьдчилж тооцоолсон дүнтэй харьцуулахад өмнөх оны мөн үеийнхээс 0,6 хувиар нэмэгдсэн байна. Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого сүүлийн 10 жилийн байдлаар дараах байдалтай байна.

### Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого



Тайлант онд нийт хураамжийн орлого 47,487.1 сая төгрөг болсон бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн орлого 17,587.8 төгрөгт хүрчээ. Энэ үзүүлэлт 2001 оноос хойш даруй 15,456.7 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 5,821.7 төгрөгөөр нэмэгдсэн байна.

### Даатгалын нөхөн төлбөр

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 10,071.8 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс барилга угсралтын даатгал 89.0 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 5.6 сая төгрөгөөр тус тус буурч, хөрөнгийн даатгал 59.1 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 1,928.1 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 2.9 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 133.1 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 509.3 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 213.0 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 335.1 сая төгрөгөөр, ачааны даатгал 140.4 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 17.2 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 9.2 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 16.2 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэйгээр нөхөн төлбөр олгожээ.

/сая төгрөгөөр/


Даатгалын хэлбэр	Даатгалын нийт нөхөн төлбөр		Өөрчлөлт /+,./-/-
	2010.12.31	2011.12.31	
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	776.5	1285.8	509.3
1.2. Хөрөнгийн даатгал	1425.5	1484.6	59.1
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	3022.3	4950.4	1928.1
1.4. Ачааны даатгал	38.4	178.8	140.4
1.5. Барилга угсралтын даатгал	89	0	-89.0
1.6. Газар тариалангийн даатгал	0	0.4	0.4
1.7. Мал амьтдын даатгал	11.4	5.8	-5.6
1.8. Агаарын хөлгийн даатгал	10.4	13.3	2.9
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	757.9	970.9	213.0
1.10. Хариуцлагын даатгал	224.1	357.2	133.1
1.11. Санхүүгийн даатгал	419.6	754.7	335.1
2.1. Хугацаат амьдралын даатгал	15	32.2	17.2
2.3. Хуримтлалын даатгал	0	16.2	16.2
2.4. Тэтгэврийн даатгал	0	0	0.0
2.5. Эрүүл мэндийн даатгал	30.7	21.5	-9.2
<b>Дүн</b>	<b>6 820.8</b>	<b>10 071.8</b>	<b>3 251.0</b>

2011 онд даатгагчийн нөхөн төлбөр 10.1 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн өмнөх үеийнхээс 8.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ үзүүлэлтээс харахад 2004 онд нөхөн төлбөр буурч байсан бол 2006 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.

### Даатгалын нөхөн төлбөр



### Нөхөн төлбөр ба хураамжийн орлого




2011 оны жилийн эцсийн байдлаар даатгалын нөхөн төлбөр 10.1 тэрбум төгрөгт хүрч, нөхөн төлбөр хураамжийн орлогын харьцаа 21,1 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй тэнцүү байна. Энэ нь хураамжийн орлого, нөхөн төлбөрийн өсөлт харьцангуй тэнцүү явж ирсэнтэй холбоотой.

### Даатгалын нөхөн олговрын түвшин

Тайлант оны жилийн эцэст даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 33,0 хувь болж 5 жилийн өмнөх үеийнхээс 10,8 пунктээр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд дундаж түвшин 34,9 хувьтай байна.

### Хохирол нөхөлтийн харьцаа



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговор олголтын түвшингээр харьцуулахад 2011 оны жилийн эцсийн байдлаар “Жонон даатгал” ХХК 77,1 хувь, “Монгол даатгал” ХХК 39,6 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна.

д/д	Компанийн нэр	2010	2011	Өөрчлөлт /пункт/
1	"Ард даатгал" ХХК	45.14	36.6	(8.52)
2	"Бодь даатгал" ХХК	26.39	30.0	3.65
3	"Ган зам даатгал" ХХК	10.41	6.8	(3.60)
4	"Мандал даатгал" ХХК	-	1.8	1.8
5	"Жонон даатгал" ХХК	84.02	77.1	(6.91)
6	"Миг даатгал" ХХК	20.22	29.1	8.87
7	"Монгол даатгал" ХХК	45.97	39.6	(6.32)
8	"Гэр даатгал" ХХК	1.32	16.3	14.99
9	"Моннис даатгал" ХХК	-	16.5	16.46
10	"Мөнх даатгал" ХХК	16.33	17.7	1.35
11	"Номин даатгал" ХХК	35.47	34.9	(0.57)
12	"Нэйшнл лайф даатгал" ХХК	34.52	16.8	(17.71)
13	"Практикал даатгал" ХХК	18.40	15.8	(2.63)
14	"Тэнгэр даатгал" ХХК	35.58	33.5	(2.03)
15	"Соёмбо даатгал" ХХК	24.67	36.8	12.12
16	"Монре даатгал" ХХК	18.94	33.1	14.13
17	"УБ хотын даатгал" ХХК	31.72	27.8	(3.92)
	<b>Дүн</b>	<b>34.00</b>	<b>33.00</b>	<b>(1.00)</b>


Тайлант онд даатгалын компаниудаас даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оныхтой харьцуулахад "Гэр даатгал" ХХК 14,99 пунктээр, "Монре даатгал" ХХК 14,13 пунктээр, "Соёмбо даатгал" ХХК 12,12 пунктээр, "Миг даатгал" ХХК 8,87 пунктээр, "Бодь даатгал" ХХК 3,65 пунктээр тус тус өсч, "Ард даатгал" ХХК 8,52 пунктээр, "Монгол даатгал" ХХК 6,32 пунктээр, бусад даатгагч нарын хувьд "Нэйшнл лайф даатгал" ХХК 17,71 пунктээр, "Жонон даатгал" ХХК 6,91 пунктээр, "УБ хотын даатгал" ХХК 3,92 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### Даатгагчийн ашигт ажиллагаа

2011 оны жилийн эцэст даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 8,180.2 сая төгрөг болсон нь өмнөх жилийн мөн үеийнхээс 1,820.0 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд "Нэйшнл лайф даатгал" ХХК 183.5 сая төгрөг, "Мандал генерал даатгал" ХХК 469.8 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг сүүлийн 5 жилийн байдлаар 10.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.





## Даатгалын нөөц сан

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2007 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 17.6 тэрбум төгрөг байсан бол 2011 оны эцэст 36.1 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 18.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин даатгалын нөөц сангийн эзэмшигчийн өмч, өр төлбөртэй харьцуулсан харьцаа сүүлийн 3 жилийн хугацаанд буурч ирсэн байна.



## Давхар даатгал

2011 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 10.7 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 тэрбум төгрөгөөр буюу 1,4 дахин өссөн дүнтэй гарсан байна.



(сая төгрөгөөр)

д/д	Компанийн нэр	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	"Ард даатгал" ХХК	689.0	9.24	1,630.8	15.22	941.8	5.97
2	"Бодь даатгал" ХХК	2,890.5	38.78	3,410.1	31.82	519.6	-6.96
3	"Тэнгэр даатгал" ХХК	1,314.6	17.63	769.3	7.18	-545.3	-10.46
4	"Практикал даатгал" ХХК	244.5	3.28	232.4	2.17	-12.1	-1.11
5	"Миг даатгал" ХХК	704.7	9.45	1,418.3	13.23	713.6	3.78
6	"Монгол даатгал" ХХК	1,370.5	18.38	568.7	5.31	-801.8	-13.08
7	"Номин даатгал" ХХК	129.0	1.73	101.9	0.95	-27.1	-0.78
8	"Нэйшнл лайф даатгал" ХХК			94.8	0.88	94.8	0.88
9	"Мандал женерал даатгал" ХХК			14.3	0.13	14.3	0.13
10	"Соёмбо даатгал" ХХК			1,603.6	14.96	1,603.6	14.96
11	"Улаанбаатар хотын даатгал" ХХК			27.0	0.25	27.0	0.25
12	"Ган зам даатгал" ХХК			111.9	1.04	111.9	1.04
13	"Моннис даатгал" ХХК			688.5	6.42	688.5	6.42
14	"Монре даатгал" ХХК			45.2	0.42	45.2	0.42
15	"Гранд даатгал" ХХК	111.7	1.50			-111.7	-1.50
	<b>Дүн</b>	<b>7454.5</b>	<b>100</b>	<b>10,716.8</b>	<b>100</b>	<b>3,262.3</b>	<b>0.00</b>

Тайлант оны жилийн эцсийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулахад "Ард даатгал" ХХК 941.8 сая төгрөгөөр, "Бодь даатгал" ХХК 519.6 сая төгрөгөөр, "Миг даатгал" ХХК 713.6 сая төгрөгөөр тус тус давхар даатгалын хураамжийн хэмжээгээ нэмэгдүүлж, "Тэнгэр даатгал" ХХК 545.3 сая төгрөгөөр, "Монгол даатгал" ХХК 801.8 сая төгрөг, "Номин даатгал" ХХК 27.1 сая төгрөг, "Практикал даатгал" ХХК 12.1 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

2011 онд шинээр "Монре даатгал" ХХК, "Соёмбо даатгал" ХХК, "Улаанбаатар хотын даатгал" ХХК, "Ганзам даатгал" ХХК, "Моннис даатгал" ХХК-иуд өөрсдийн хүлээсэн эрсдэлээ гадаадын давхар даатгагч нарт даатгуулсан нь 2011 оны давхар даатгалын нийт хураамжийн хэмжээ 1,4 дахин өсөхөд нөлөөлсөн байна.

#### 4.2. МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТАЛААР

Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын төсөл нь 2005 оноос эхлэн "Монгол даатгал" ХХК, "Тэнгэр даатгал" ХХК, "Соёмбо даатгал" ХХК /хүүчин нэрээр "Түшиг даатгал" ХХК/, 2006 оноос "Бодь даатгал" ХХК, 2010 оноос "Практикал даатгал" ХХК-иудтай хамтран малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг зуд, байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах тогтолцоог Монгол Улсад анх удаа нэвтрүүлэн ажиллаж байна.


Хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 177 дугаар тогтоолоор "Малын индексжүүлсэн даатгалыг бүртгэх, тайлагнах түр заавар"-ыг батлан гаргасан бөгөөд уг зааврын дагуу малын индексжүүлсэн даатгалын төслийг хэрэгжүүлж буй ердийн даатгалын компаниудын орлого дараах байдалтай байна.

/сая төгрөгөөр/

д/д	Компанийн нэр	Малчны төлсөн хураамж	Орлогот тооцсон хураамж	Үйл ажиллагааны зардал	2010 оны нөхөн төлбөр
1	"Монгол даатгал" ХХК	364.4	267.2	121.4	48.1
2	"Практикал даатгал" ХХК	76.0	100.8	25.3	13.7
3	"Тэнгэр даатгал" ХХК	185.7	185.4	61.4	11.2
4	"Бодь даатгал" ХХК	221.2	24.6	73.6	35.3
	<b>Дүн</b>	<b>847.3</b>	<b>578.0</b>	<b>281.7</b>	<b>108.3</b>

2011 оны борлуулалтын жилд нийт 847,3 сая төгрөгний борлуулалт хийсний 43 хувийг “Монгол Даатгал”, 26,1 хувийг “Бодь даатгал”, 21,9 хувийг “Тэнгэр Даатгал”, 9 хувийг “Практикал даатгал” компани тус тус эзэлж байна. Харин нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн 39,8 хувийг “Монгол даатгал”, 24,7 хувийг “Бодь даатгал”, 24,1 хувийг “Тэнгэр даатгал”, 11,4 хувийг “Практикал даатгал” компаниуд тус тус эзэлжээ.

#### Даатгалын компаниудын малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого (дүнд эзлэх хувиар)



#### 4.3. Даатгалын зуучлагчийн талаар

Тайлант оны жилийн эцэст нийт 8 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 314.0 сая төгрөг болсон ба үүнээс 89,1 хувь буюу 280.0 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

д/д	Компанийн нэр	2010.12.31	2011.12.31	/сая төгрөгөөр/ Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	35.8	28.9	-6.9
2	“Аме” ХХК	23.5	25.9	2.4
3	“Ачит ундарга” ХХК	24.9	73.1	48.2
4	“Лоялти солюшн” ХХК	34.6	48	13.4
5	“Эм жи ай би” ХХК	23.8	15.4	-8.4
6	“Ренессанс групп” ХХК	12	38.3	26.3
7	“Жомолхари” ХХК	0	5.5	5.5
8	“Скай эрдэнэ” ХХК	22.7	0	-22.7
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	0	44.9	44.9
	<b>Дүн</b>	<b>177.3</b>	<b>280.0</b>	<b>102.7</b>

Тайлант оны хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Аме” ХХК 2.4 сая төгрөгөөр, “Лоялти солюшн” ХХК 13.4 сая төгрөгөөр, “Ачит ундарга” ХХК 48.2 сая төгрөгөөр, “Ренессанс групп” ХХК 26.3 сая төгрөгөөр, “Жомолхари” ХХК 5.5 сая төгрөгөөр, “Монголиан интернэшнл брокерс” ХХК нь 44.9 сая төгрөгөөр тус тус өссөн бол “Асимон брокерс” ХХК 8.6 сая төгрөгөөр, “Эм жи ай би” ХХК 8.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна. 2011 оны 8 дугаар сард “Скай-эрдэнэ” ХХК-ийн даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Ачит ундарга” ХХК-иудын олсон орлого нийт даатгалын зуучлалын үндсэн үйл ажиллагааны орлогын 42.2 хувийг эзэлсэн байна.

#### 4.4. Даатгалын хохирол үнэлэгчийн талаар

Тайлант жилд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 154.4 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 17,5 хувь буюу 27.1 сая төгрөг болж, үлдсэн 82,5 хувийг бусад орлого эзэлж байна.

д/д	Компанийн нэр	2010.12.31	2011.12.31	/сая төгрөгөөр/ Өсөлт бууралт
1	"Бест эстимэйт" ХХК	14.3	1.7	-12.6
2	"Гэрэгэ эстимэйт" ХХК	4.9	13.8	8.9
3	"Файн эстимэйт" ХХК	3.5	0	-3.5
4	"Итгэлт эстимэйт" ХХК	7.9	0	-7.9
5	"Мега марз" ХХК	5.4	5.5	0.1
6	"Вендо" ХХК	0	5.5	5.5
7	"Жи ай си си" ХХК	-	0.4	0.4
8	"Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК	53.6	0.2	-53.4
	<b>Дүн</b>	<b>89.6</b>	<b>27.1</b>	<b>-62.5</b>

2011 оны тайлант үеийн хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад "Гэрэгэ эстимэйт" ХХК 8.9 сая төгрөгөөр, "Вендо" ХХК 5.5 сая төгрөгөөр тус тус өсч, бусад хохирол үнэлэгч компаниудын даатгалын хохирол үнэлгээний орлого буурсан байна.

Тайлант хугацаанд "Файн эстимэйт" ХХК даатгалын хохирол үнэлгээний орлогыг төвлөрүүлж ажиллаагүй бөгөөд "Итгэлт эстимэйт" нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байсан байна.

#### 4.5. Даатгалын салбарт цаашид анхаарах асуудлууд

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн жилүүдийн байдлаар дүгнэж харахад даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, даатгалын байгууллагуудын тоо 2009 оноос хойших хугацаанд эрс нэмэгдэх хандлагатай болсон нь даатгалын мэргэжлийн оролцогч компаниуд шинээр байгуулагдаж, Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажилласантай холбоотой.

Даатгалын байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2010 онд 38 хувиар, 2011 онд 43,2 хувиар тус тус өсч, 2011 оны жилийн эцэст 81.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ тайлант онд 48 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 1,5 дахин нэмэгдсэн, даатгалын компаниудын өнгөрсөн оны цэвэр ашиг 10.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 3 дахин өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи бэхжиж, цаашид даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжрах төлөвтэй байгааг илтгэн харуулж байна.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт орлого ихээхэн өссөн дүнтэй гарсан нь нэг талаас даатгалын зах зээлийн хамралт нэмэгдэж тэлсэн, нөгөө талаас даатгалын үнэлгээ болон үнийн ерөнхий өсөлттэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлтүүд эерэг хандлагатай, өсөлттэй гарч байгаа хэдий ч даатгалын салбарт дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Даатгалын салбарт эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлж, Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулах зорилтын хүрээнд даатгалын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Монголбанк, Сангийн яам зэрэг төрийн болон засгийн газрын байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог боловсронгуй болгох нь зүйтэй байна. Юуны өмнө хамтарсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлж мэдээлэл солилцох, яам, агентлаг хоорондын мэдээллийн нэгдсэн сангийн сүлжээ бий болгохоос ажлаа эхлүүлэх;

2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монгол Улсад даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгалын байгууллагуудад шууд даатгуулах явдал ихээр гарсаар байна. Энэ нь манай дотоодын даатгагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөс гадна гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд өөрсдийн зардлыг нэмэгдүүлж, Монгол Улсад татвар төлөхгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлж байгааг анхаарах;

3. Даатгалын компаниудын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөнд нөөц сангийн эзлэх хувь хэмжээ сүүлийн 3 жил дараалан буурсаар ирсэн нь даатгалын компанийн эрсдэл даах санхүүгийн чадавхид сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд даатгалын актуар тооцооллыг даатгалын байгууллагуудад тууштай нэвтрүүлэх ажлыг дэмжих зорилгоор холбогдох олон улсын байгууллагуудын оролцоотойгоор актуарчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулах;

4. Иргэд, даатгуулагчдын санхүүгийн болон даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтаар тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах нь зүйтэй байна.

## **ТАВ. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА САНХҮҮГИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР:**

Манай улсын эдийн засаг өсөж, эдийн засаг, санхүүгийн салбарт хөгжил дэвшил нэмэгдэхийн хирээр энэ салбарт шинэ бүтээгдэхүүн, шинэ харилцаа үүссээр байна. Үүнийг дагаж хууль, эрх зүйн болоод бодлогын зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ. Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсанаас хойш Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн асуудал, Компанийн зээлжих зэрэглэлийн асуудал буюу зэрэглэл тогтоох үйл ажиллагаа, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зохицуулалтын зарим асуудал, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулалтын зарим асуудлууд Хорооны зохицуулалтын хүрээнд шинээр нэмэгдсэн.

Эдгээр асуудлуудыг хариуцсан дотоод зохион байгуулалтыг тодорхой болгох, улмаар энэ асуудлуудад оновчтой бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2011 оны 7 дугаар сард Хорооны бүтэц чиг үүргийг өөрчилж дээрх асуудлуудыг хариуцсан Эрсдлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газрыг байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлсэн болно.

Энэ чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

- Даатгалын байгууллагад хийгддэг аудитын ажлын чанарыг сайжруулах, шалгуурыг тодорхой болгох үүднээс “Аудитын чанарын хяналтын түр журам”-ын төслийг боловсруулан Хорооны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, 209 дүгээр тогтоолоор батлуулж мөрдөн ажиллаж байна. Нийт 14 аудитын компанийн 36 аудиторруудад “Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох” төрөлжсөн сургалт явуулж, шалгалт авсны үндсэн дээр эрх олгох асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлүүлсэн.
- Хөрөнгийн үнэлгээний хуулийн хэрэгжилтийг хангах, зарим асуудлыг нарийвчлан зохицуулах, зохицуулалтын хүрээний байгууллагатай холбоотой хийгдэх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний арга, аргачлалыг тодорхой болгох ажлын хүрээнд “Бизнесийн үнэлгээний аргачлал”-ыг боловсруулан Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 274/240 дүгээр тушаалаар батлууллаа.
- Уул уурхайн компаниуд Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргах замаар үйл ажиллагаанд шаардагдаж буй их хэмжээний хөрөнгийг босгох сонирхол сүүлийн үед идэвхижсэн, мөн банк

болон банк бус санхүүгийн байгууллагуудад лицензээ барьцаалан зээл авах тохиолдол түгээмэл байгаа билээ. Гэвч уул уурхайн компаниудын эрдэс баялаг, ашигт малтмалын нөөц, хөрөнгө, бизнесийн үнэлгээ нь бодит байдлаас хол зөрүүтэй хийгдэж байгаагаас хөрөнгө оруулагчдыг татаж чадахгүй байх, эсвэл бодит бус мэдээлэлд тулгуурлан хөрөнгө оруулагчид шийдвэрээ гаргах эрсдэлүүд бий болоод байгаа билээ. Иймд эрдэс баялаг, ашигт малтмалын хөрөнгө, бизнесийн үнэлгээний арга, аргачлал, олон улсын стандартыг нутагшуулан, тухайн чиглэлийн мэргэшсэн үнэлгээчдийг бэлтгэх тогтолцоо бүхий орчныг бүрдүүлсэнээр хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах, улмаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Энэхүү ажлын хүрээнд эрдэс баялаг, ашигт малтмалын үнэлгээний олон улсын стандартыг нутагшуулах төсөл хэрэгжүүлэхээр анхан шатны судалгаа хийх ажлыг эхлүүлж, үнэлгээний аргачлалын жишиг загвар боловсруулах зөвлөх үйлчилгээний баг шалгаруулах баримт бичгийг бэлтгээд байна.

- Тайлант онд Хороонд шинээр болон нэмж хувьцаа гаргах, бонд гаргах, өрийг хувьцаагаар солихоор 10 компаниас, үнэт цаасаа бүртгэлээс хасуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой 8 компаниас ирүүлсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, төсөл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, холбогдох баримт бичгийг хянаж, үнэлгээний бодитой эсэх, төслийн хэрэгжих магадлал, санхүүгийн тайлангийн үнэн зөв эсэх, санхүүгийн тайлангийн аудитын чанарын талаар нийт 24 дүгнэлт гарган Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлжээ.
- Төслийн үнэлгээ хянах ажлын хүрээнд “Жаст Агро” ХХК-ийн Баян-Өлгий, Дорнод аймаг, Улаанбаатар хотын салбарууд, “Силикат” ХК, “Бэрэн майнинг” ХХК, “Э-транс ложистик” ХХК, “Дархан хүнс” ХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх үзлэг шалгалтыг хийж холбогдох дүгнэлтийг гаргаж ажиллалаа.
- Санхүүгийн тайлагналын чанарыг сайжруулах механизм бүрдүүлэх нь санхүүгийн зах зээлд оролцогчдод хүрэх мэдээллийн бодит байдлыг хангах замаар энэхүү зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор даатгалын байгууллагад аудит хийх эрх олгохоос бусад аудит, үнэлгээний үйл ажиллагаа эрх зүйн хувьд Хороотой хамааралгүй байдаг. Иймээс эдгээр мэргэжилтнүүдийн харьяалагддаг мэргэжлийн байгууллагууд болох Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт /ММНБИ/, Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтууд /ММҮИ/-тэй зөвшилцсөний үндсэн дээр “Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх журам”-ыг боловсруулах ажлыг эхлүүлж, журамд тусгагдах гол гол асуудлуудын талаар санал асуулга, ярилцлага зохион байгуулж журмын төслийн эхний хувилбарыг бэлтгэлээ.
- Сангийн Яам, ММНБИ-тэй хамтран Даатгалын байгууллагуудын 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн 15 аудитын компанийн гүйцэтгэлд чанарын хяналт хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгах болон цаашид анхаарах асуудлуудын талаар аудитын компаниуд болон аудиторуудад үүрэг өгсөн.
- Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай “Зээлийн мэдээллийн сан ашиглах гэрээ” байгуулж Зээлийн мэдээллийн сангийн зээлдэгчийн талаарх мэдээллийг Хорооны дотоод хэрэгцээнд ашиглаж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор Хорооны хэрэгцээнд “Монголбанкны Зээлийн мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл авах, ашиглах заавар”-ыг боловсруулж Хорооны даргын 2011 оны 181 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.
- Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагуудад эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх чиглэлийн бодлого боловсруулах ажлыг эхлүүлээ.
- Компанийн зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл ажилд оролцох зэрэг ажлуудыг эхлүүлсэн.
- Хорооны зохицуулалтын байгууллагуудын санхүүгийн тайлагналын хяналт, үнэлгээг сайжруулсанаар СЗХ-ны чадавхийг бэхжүүлэх төслийг Дэлхийн Банктай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- “Монголрейтинг сервис” ХХК-ийн зэрэглэл тогтоох үйлчилгээ, үйл ажиллагаанд хийсэн шалгалтыг үндэслэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн талаарх мэдээлэл, тайлбарыг Хороонд ирүүлэхийг компанийн удирдлагад үүрэг болгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
- “Монгол улсын даатгалын салбарын Санхүүгийн тайлагнал ба даатгалын зах зээлийн хөгжил” сэдэвт сургалт, Компанийн засаглалын хөгжлийн төв болон СЗХ, Олон Улсын санхүүгийн корпорациас хамтран зохион байгуулсан “Компанийн шинэчлэн батлагдсан хууль ба Компанийн засаглал” сэдэвт бага хурал, Монголын ипотекийн корпорацаас зохион байгуулсан “Бизнесийн үнэлгээ” сэдэвт семинар, Эрсдэлийн удирдлагын форум, Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны улсын V зөвлөлгөөн, Германы техник туслалцаа, хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрөөс зохион байгуулсан “Зээлийн батлан даалтын сан байгуулах нь” сэдэвт семинар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Ядуурал, МХЗ-уудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих” төслөөс зохион байгуулсан “Хөгжлийн бодлого ба стратеги төлөвлөлт” сэдэвт сургалт, семинаруудад тус тус хамтран оролцсон.
- Хорооны Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газраас Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах ажилтанд эрх олгох болон эрх сунгах сургалтанд “Үнэт цаас гаргах болон үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалтын бүртгэл”, “Шинээр үнэт цаас гаргахад аудиторын болон үнэлгээний компанийн үйл ажиллагааны процесс, үүрэг хариуцлага, стандарт шаардлага, арга аргачлал, хэрэглээ”, “Даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн онцлог” гэсэн тодорхой сэдвүүдээр 16 цагийн хичээлийг заасан бөгөөд нийт 210 гаруй иргэн, холбогдох газруудын 20 ажилтан, Даатгалын байгууллагын 29 аудитор хамрагдсан.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Хорооны мэдэгдэл, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажлууд болон хуулийн талаарх түгээмэл асуулт, хариултыг боловсруулан мэдээллийг Хорооны цахим хуудасаар /[www.frc.gov.mn/](http://www.frc.gov.mn/) дамжуулан олон нийтэд түгээж ажиллав;
- Хууль зөрчиж буй талаар болон бусад холбогдох мэдээллийг иргэд, байгууллагаас авах цахим мэдээллийн талбар нээн ажиллуулж байна. Мөн нийгмийн цахим сүлжээний Твиттер, Фэйсбүүкд хуудас нээж хуультай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээж, мэдээлэл авч ажиллаж байна. Түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс 26-16-62 утсаар мэдээлэл хүлээн авч бүртгэдэг;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг тухайн орон нутагт зохион байгуулах, цаашид Хороотой хамтран ажиллах талаар бүх аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт албан бичиг хүргүүлэв;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас хилийн боомтуудад гадаад валютаар төлбөр тооцоог гүйцэтгэх асуудал гарсаар байгаа талаар ирүүлсэн албан бичгийн хүрээнд Хөвсгөл, Өмнөговь зэрэг аймгийн удирдлагад орон нутагт хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарлаа хандуулж, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлэв;
- Үүрэн телефоны оператор компаниуд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх, аливаа этгээдийн гадаад валют болон тооцооны нэгжээр илэрхийлсэн зар сурталчилгааг олон нийтэд түгээхгүй байх чиглэлээр албан бичиг хүргүүлж, хамтран ажиллаж байна.

## **ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛООД БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР**

Хороо нь тайлант онд гадаад хамтын ажиллагааны хувьд уламжлалт харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжиж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

6.1.Хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудын туслалцаатайгаар Санхүүгийн салбарт хэрэгжүүлж болох төсөл, хөтөлбөрийн боломжийн талаар 2011 оны 3 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд болон Сангийн дэд сайд , Хорооны дэд дарга нарын бүрэлдэхүүнтэй хурлыг зохион байгуулж, хурлаар Санхүүгийн салбарт яаралтай хэрэгжүүлэх арга хэмжээг Сангийн яамны дэргэд хэрэгжиж буй Дэлхийн Банкны хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэхээр тохиролцсоны үр дүнд Үнэт цаасны тухай хуулийн төслийн ажлын хэсгийн хуралдааныг Дэлхийн Банкны санхүүжилтээр зохион байгуулсан.

6.2. Азийн Хөгжлийн Банктай урьд тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчинд тулгамдсан асуудал сэдвээр Залуу судлаачдын онол практикийн бага хурлыг зохион байгуулж, хуралдааны үеэр тавьсан илтгэл, тайлан, зөвлөмжийг эмхэтгэж, товхимол болгон хэвлүүлсэн болно.

6.3.Олон улсын байгууллагуудтай хамтран санхүүгийн зах зээлд оролцогч дотоодын байгууллага, иргэдэд Олон улсын болон бүс нутгийн хэмжээний сургалт семинарт оролцуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдөрлөг, Санхүүгийн форум, Компанийн засаглалын 4 дүгээр форум, Улсын мөрдөн байцаах газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс зохион байгуулагдсан Чуулга уулзалтыг тус тус зохион байгуулсан.

6.4.Гадаадын ижил төрлийн байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөтгөх ажлын хүрээнд БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороотой 2011 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж мөрдөн ажиллаж байна.

6.5.БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хороо/CSRC/, Польш улсын Санхүүгийн хяналт шалгалтын агентлагтай хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд харилцан айлчлах тухай захидал хүргүүлж, ИБУИНВУ-ын Санхүүгийн үйлчилгээний байгууллага /FSA/-тай Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах саналыг санамж бичгийн төслийн хамт хүргүүлэн ажиллалаа.

6.6.Гадаадын хандивлагч, хөрөнгө оруулагч нарын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх төслийн хэрэгжилтийг хангах 4 чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байлаа. Үүнд:

- Люксембургийн Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлэх СЗХ-ны чадавхийг бэхжүүлэх төсөл 2011 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр албан ёсоор эхэлсэн бөгөөд СЗХ-ны 2011-2015 хооронд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулахад гадаадын шинжээч урин ажиллуулж стратеги төлөвлөгөөг боловсруулсан;
- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн шугамаар хэрэгжүүлж байсан “Эдийн засгийн Бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар” төсөл дуусгавар болж, “Бизнесийн хөгжлийг дэмжих төсөл”-ийг 2011 оны 8-р сараас хэрэгжүүлж эхэлсэн ба Хороо нь тус төсөлтэй санхүүгийн салбарт хамтран ажиллах түнш байгууллагаар сонгогдон ажиллаж байна.
- Олон улсын санхүүгийн хүртээмжийн холбооны Мэдлэг солилцох хөтөлбөрийн хүрээнд мобайл банкны үйлчилгээний эрх зүйн орчин, зохицуулалт, хяналт, учирч болох эрсдэлийг судалж, орон нутгийн алслагдмал газарт амьдардаг, банкны үйлчилгээнд хамрагдах боломжгүй иргэдэд банк, санхүүгийн үйлчилгээг хямд өртгөөр хүргэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төслийг боловсруулсан;



- Канадын хоршоодын холбооны төслийн хүрээнд бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, төслийг бүрэн хэрэгжүүлж дууссан тухай тайланг хүргүүлж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Бичил даатгалын төсөл”-ийг хэрэгжүүлэх төслийн нэгжтэй хамтран ажиллаж, төслийн явц, гарсан үр дүнгийн талаар танилцуулж, шаардлагатай мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

## **ДОЛОО. ХОРООНЫ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ БА УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Тайлант онд Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагуудад зайнаас тавих хяналтын FINA системийг нутагшуулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж одоогоор Хадгаламж зээлийн хоршоодын санхүүгийн тайлан, Банк бус санхүүгийн байгууллагын валютын арилжааны мэдээ, Үнэт цаасын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд болон даатгалын байгууллагуудын санхүүгийн тайланг цахим маягаар тус тус хүлээн авч боловсруулалт хийдэг болгох ажлыг нэвтрүүлж, хэвшүүлэх ажил хийгдэж байна.

Мөн Хорооны мэдээллийн урсгалын аюулгүй байдлыг сайжруулах, хяналтын системийг боловсронгуй болгохоор Люксембургийн төслийн санхүүжилтээр мэдээллийн бааз сууриа бэхжүүлсэн ба одоогоор суурилуулалт, төстийн ажлыг гүйцэтгэх шатанд явагдаж байна.

## **НАЙМ. ХОРООНЫ 2011 ОНЫ ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН**

### **8.1. Үндсэн үйл ажиллагааны орлого**

Санхүүгийн Зохицуулах Хорооны Эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.3-д заасны дагуу Хорооны санхүүжилт нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалт үйлчилгээний хөлс, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлогоос тус тус бүрдүүлж, үйл ажиллагаагаа санхүүжүүлэн ажиллаж ирлээ. 2006 – 2011 онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэн авсан зохицуулалт үйлчилгээний хөлс 2006 онд 60.3 сая.төг, 2007 онд 595.0 сая.төг, 2008 онд 567.3 сая. төг, 2009 онд 417.2 сая.төг, 2010 онд 692.5 сая.төг, 2011 онд 960.1 сая төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн.

Тайлант онд 960.1 сая.төг төвлөрч, батлагдсанаас 433.6 сая.төг буюу 182,4 %-иар давж биелсэн ба нийт орлогын 1.4% буюу 13.8 сая.төг нь Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын, 9.1% буюу 87.7 сая.төг нь Үнэт цаасны үйл ажиллагааны зохицуулалтын, 14.7 % буюу 140.7 сая.төг нь Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалтын, 22.2% буюу 213.0 сая.төг нь Даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын, 50.9 % буюу 489.1 сая. төг нь “ҮЦТТХТ” ХХК-ийн үйл ажиллагааны зохицуулалтын төлбөр, хураамжийн орлогоос, 1.7 % буюу 15.8 сая.төг нь торгууль, шийтгэврийн орлогоос тус тус бүрдсэн байна.

### **8.2. Төсвийн санхүүжилтийн үйл ажиллагаа**

Тайлант оны батлагдсан төсвийн урсгал санхүүжилтийн 58,1%-ийг улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр, 41,9%-ийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалтын үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээр тус тус санхүүжүүлж, Хорооны үйл ажиллагааг жигд тогтмол тасралтгүй явуулахад хөрөнгө, орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, төсвийн урсгал санхүүжилтийг 9.1 сая.төг буюу 0,8%-иар хэмнэсэн ба 2010 оны төсвийн орлого давалтын эх үүсвэрээр 155.2 сая.төг-ийг Сангийн Сайдын тушаалын дагуу тооцон, журам зааврын дагуу Хорооны ажилтан, албан хаагчдын орон сууц худалдан авах, нөхцөл сайжруулахад дэмжлэг үзүүлэх, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд тус тус зарцуулж, Улсын төсөвт төвлөрүүлэх орлогоор 264.2 сая төгрөгийг төвлөрүүлэн ажиллаж ирлээ.

## Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2009-2011 оны төсөв хөтөлбөрийн ангиллаар

/сая төгрөг/

Хөтөлбөр	Нийт төсөв			Үрсгал			Хөрөнгө оруулалт
	2009	2010	2011	2009	2010	2011	
Нийт дүн	719.6	911.6	985.6	719.6	911.6	1091.6	-
1.Санхүүгийн салбарын зохицуулалт	230.1	361.5	466.8	230.1	361.5	433.4	-
2.Санхүүгийн хяналт, шалгалт	488.9	550.1	518.8	488.9	550.1	658.2	-

Хорооны даргын 2011 оны төсөв, хөтөлбөрийн ангилалыг зардлын бүтцээр нь авч үзвэл: Нийт зардлын 66,5%-ийг цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал үүнээс 76.9% нь үндсэн цалин, 7.3% нь нэмэгдэл урамшил, 6.2% нь унаа хоолны хөнгөлөлт, 9.6% нь нийгмийн даатгалын шимэтгэл, 22.5% нь бараа үйлчилгээний бусад зардал үүнээс 3.3% нь бичиг хэргийн зардал, 10.8% нь тээвэр шатахууны зардал, 23.5% нь шуудан холбооны зардал, 10.8% нь дотоод албан томилолтын зардал, 12.2% нь гадаад томилолтын зардал, 2.6% нь эд хогшил худалдан авах зардал, 1.8% нь үрсгал засварын зардал, 5.5 % нь төлбөр хураамжийн зардал, 0.7 % нь гадаад зочны зардал, 23.7% нь сургалт, хурал зөвлөгөөний зардал, 5.1% нь мэдээлэл сурталчилгааны зардал, 11.0% нь татаас ба үрсгал шилжүүлгийн зардал, 38.6% нь олон улсын гишүүн байгууллагын татварын зардал тус тус эзэлж байна.

2007–2011 оны төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвөөс тооцож үзэхэд 2007 онд 2,3% буюу 11.9 сая.төг-өөр, 2009 онд 2,2% буюу 19.3 сая.төг-өөр, 2010 онд 0,8% буюу 6.9 сая.төг-өөр, 2011 онд 0,8% буюу 9.1 сая.төг-өөр тус тус хэмнэсэн үр дүнтэй байна.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт 99,8%, бүртгэлийн программ хангамж нэвтрэлт 100,0%, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулалт 100,0%, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцэл гаргалт, тушаалт 100,0 %-ийн тус тус үзүүлэлттэйгээр байнгын болон байнгийн бус өр авлагагүй ажиллалаа.

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО